



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.1, 27¹.1.4, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ыг нэгдүгээр, "Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ыг хоёрдугаар, "Тусгаарлан эмчлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /С.Энхболд/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Болд/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга /Т.Гантулга/, Улсын онцгой комиссын Шуурхай штаб, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын орлогч дарга /хошууч генерал Г.Ариунбуян/-д даалгасугай.

4. Түр журам батлагдсантай холбогдуулан Улсын онцгой комиссын "Түр журам, заавар батлах тухай" 2021 оны 31, 32 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

Улсын онцгой комиссын даргын 2021 оны
43 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТУСГААРЛАН АЖИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журмын зорилго нь Коронавируст халдвар (КОВИД-19) /цаашид “коронавируст халдвар” гэх/-ын үед гадаад улсаас ирсэн хүн (Монгол Улсын болон гадаадын бүх насны иргэн)-ийг тусгаарлах байранд тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохион байгуулах, халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтан, тусгаарлагдсан хүний хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход оршино.

1.2.Тусгаарлан ажиглах үйл ажиллагаанд Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3.“Тусгаарлан ажиглах” гэж гадаад улсаас ирсэн хүнийг тусгай шаардлагын дагуу урьдчилан бэлтгэсэн байранд тусгаарлан ажиглах, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хяналтад байлгахыг хэлнэ.

1.4.Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг улсын хэмжээнд Улсын онцгой комиссын Шуурхай штаб /цаашид “УОКШШ” гэх/, орон нутагт аймаг, сумын онцгой комиссын Шуурхай штаб /цаашид “АСШШ” гэх/ нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

1.5.Тусгаарлан ажиглах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

1.5.1.хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;

1.5.2.хууль дээдлэх, хүний эрхийг хангах;

1.5.3.шуурхай, ил тод байх;

1.5.4.хувь хүний нууцыг чанд хадгалах;

1.5.5.байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах;

1.5.6.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

1.5.7.тусгаарлан ажиглах байрны нэг өрөөнд нэг хүн, нэг гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хамтран амьдрагчийг хамтад нь байрлуулах.

1.6.Тусгаарлан ажиглах үйл ажиллагааны баримт бичгийг хуулийн этгээд бусдад шилжүүлэх, дамжуулахдаа цахим гарын үсэг хэрэглэнэ.

Хоёр. Тусгаарлан ажиглалтын хугацаа, зохион байгуулалт, шинжилгээ

2.1.Дараах тохиолдолд тусгаарлан ажиглах байранд 7 хоног тусгаарлана:

2.1.1.гадаад улсаас ирж байгаа коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдаагүй, вакцинжуулалтын бүрэн тун хийлгээгүй хүн;

2.1.2.коронавируст халдварын батлагдсан тохиолдол /цаашид “батлагдсан тохиолдол” гэх/-ын ойрын хавьтлыг тандалтын багийн саналыг харгалзан;

2.1.3. энэ журмын 2.1.1-т заасан хүүхдийг коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн, сүүлийн 4 сарын хугацаанд коронавируст халдвараар өвчилж, эдгэрсэнээс үл хамааран эцэг/эх, асран хамгаалагчийн хамт;

2.1.4.гадаад улсад зорчсон нисэх багийн бүрэлдэхүүн хил нэвтэрсэн, хил нэвтрээгүй боловч хяналт тавьсан улсын байцаагч халдвараас сэргийлэх дэглэм зөрчсөн гэж дүгнэвэл тус нисэх багийн бүрэлдэхүүн;

2.2.Гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгч, олон улсын байгууллагын суурин төлөөлөгч, ажилтан болон эдгээрийн гэр бүлийг тухайн улсын дипломат төлөөлөгчийн газрын байранд тусгаарлаж болно.

2.3.Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдаж байгаа хүнээс 6 дахь хоногт 1 удаа бх-ПГУ шинжилгээг авах ажлыг нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/, нийслэлийн Эрүүл мэндийн газар, орон нутагт харьяа Эрүүл мэндийн байгууллага зохион байгуулна. Тусгаарлалтын хугацаанд халдварын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн даруйд антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ хийж, сөрөг гарвал бх-ПГУ шинжилгээ хийнэ.

2.4.Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдах хугацаа дууссан, эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй, бх-ПГУ шинжилгээний хариу “сөрөг” гарвал гэрийн ажиглалтад шилжүүлнэ.

2.5.Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдах хугацаанд коронавируст халдварын тохиолдол батлагдвал эмнэлэгт шилжүүлнэ.

2.6. Дараах тохиолдолд хүнийг тусгаарлан ажиглах байранд тусгаарлахгүй:

2.6.1.коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн;

2.6.2.сүүлийн 4 сарын хугацаанд коронавируст халдвараар өвчилж, эдгэрсэн;

2.7.Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдахгүй иргэн вакцинжуулалтын бүрэн тунд хамрагдсан, эмчлүүлж эдгэрсэн талаархи нотломжоо үнэн зөв гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

2.8.Тусгаарлан ажиглах байранд эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн байгууллагын алба хаагч, зохион байгуулагч, үйлчилгээний ажилчид үүрэг гүйцэтгэнэ.

2.9.Тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэх үед батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй бол вакцинжуулалтын бүрэн тунд хамрагдаагүй, бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоног өнгөрөөгүй албан хаагч, тусгаарлах байрны ажилчдаас бх-ПГУ шинжилгээ авч, “сөрөг” хариу гарвал гэрийн тусгаарлан ажиглалтад 7 хоног шилжүүлнэ.

2.10.Тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэх үед батлагдсан тохиолдол бүртгэгдсэн бол ажилласан төрийн албан хаагч, тусгаарлах байрны ажилчдыг үргэлжлүүлэн ажиллуулах, тусгаарлан ажиглах байр руу шилжүүлэх эсэхийг тандалтын багийн дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Онцгой комиссын шуурхай штаб шийдвэрлэнэ.

2.11.Иргэнийг тусгаарлан ажиглах байранд хамгаалан хүргэх, хүлээлгэн өгөх ажлыг Цагдаагийн байгууллагын хамгаалалт дор зохион байгуулна.

2.12.Тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагч, ажилтнаас эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн, эсвэл шинжилгээний “эерэг” хариу гарсан тохиолдолд тусгаарлан ажиглах байрнаас бусад хүнийг гаргахыг тандалтын багийн дүгнэлтийг үндэслэн тухайн шатны ОКШШ шийдвэрлэнэ. Тандалт судалгааг боломжит богино хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Гурав. Тусгаарлан ажиглах байр, түүнд тавигдах шаардлага

3.1. Тусгаарлан ажиглах байрыг дараах эрэмбээр сонгоно:

3.1.1.зочид буудал,

3.1.2.амралтын газар, сувилал,

3.1.3.гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын байр,

3.2.Тусгаарлан ажиглах байрыг сонгох ажлын хэсгийг нийслэлд дүүргийн Онцгой комиссын даргын тушаалаар, орон нутагт аймгийн Онцгой комиссын даргын тушаалаар томилно.

3.3.Хуулийн этгээд нь энэ журмын 3.1-т заагдсан байрыг тусгаарлан ажиглах байрын зориулалтаар ашиглуулах хүсэлтээ ажлын хэсэгт гаргана. Ажлын хэсэг нь уг хүсэлтийг судлан үзэж, энэхүү журмын 3 дахь хэсэгт заасан шаардлагад нийцсэн объектыг тусгаарлан ажиглах байраар сонгоно.

3.4.Сонгогдсон байрны дүгнэлт, дэлгэрэнгүй мэдээллийг ажлын хэсгээс УОКШШ, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт хүргүүлнэ.

3.5.Тусгаарлан ажиглах байрны эзэмшигчтэй байгуулах гэрээний загварыг онцгой байдлын байгууллага боловсруулж, санхүүгийн төлбөр тооцооны гүйцэтгэлд хяналт тавина.

3.6.Тусгаарлан ажиглах байр нь дараах шаардлагыг хангасан байна:

3.6.1.цахилгаан, дулаан, усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн болон хэсгийн системд холбогдсон, галын аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангасан байх;

3.6.2.ундны усны хэсгийн систем, эх үүсвэр, хэрэглээний шугамын усанд мэргэжлийн хяналтын байгууллагаар нян судлалын шинжилгээг хийлгэж, дүгнэлт гаргуулсан байх;

3.6.3.цонхны салхивчийг нээх боломжтой, эсвэл агааржуулалтын системтэй, насанд хүрээгүй иргэний аюулгүй байдлыг хангасан байх;

3.6.4.өрөө тус бүр гар угаах нөхцөлөөр хангагдсан бие засах ариун цэврийн өрөөтэй, нэг өрөөнд энэ журамд заасан нөхцөлөөр иргэнийг хамт тусгаарласан тохиолдолд ор хоорондын зайг нэг метрээс доошгүй байх;

3.6.5.эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн алба хаагчийн байрлах өрөө нь гар угаах, усанд орох, бие засах нөхцөлөөр хангагдсан эсвэл гар угаах, усанд орох хэсэг нь ажиглалтад байгаа иргэнээс тусдаа байхаар зохион байгуулагдсан байх;

3.6.6.хяналтын камер, зарлан мэдээлэх төхөөрөмжийг давхар бүрт бүрэн хянах боломжтойгоор байрлуулсан, камерын бичлэг нь тусгаарлалтын нэг ээлжийн бичлэгийг бүрэн хадгалах хүчин чадалтай байх;

3.6.7.албан хаагчдын амрах, хоол үйлдвэрлэх, сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах, цэвэрлэгээний материал, угааж халдваргүйжүүлж, хадгалах өрөө, хамгаалах хувцас өмсөж, тайлах хэсэгтэй байх;

3.6.8.тусгаарлагдаж байгаа хүн, үүрэг гүйцэтгэж буй ажилтныг чанар, эрүүл, аюулгүй байдлын шаардлага хангасан хоол, хүнсээр хангах боломжтой байх.

3.6.9.өрөө бүрт дараах эд зүйлийг урьдчилан бэлтгэж байршуулсан байх:

а/ ариун цэврийн цаас, гарын болон эдийн саван, аяга, таваг угаагч шингэн, цэвэрлэгээний алчуур (гал тогооны, тоосны, шалны), өрөө, тасалгаа, ариун цэврийн өрөөнд хэрэглэх угаалга, цэвэрлэгээний бодис, хогийн сав, хар, шар өнгийн хогийн уут,

б/ "Эмнэлзүйн шинж тэмдэг тандах хуудас", халуун хэмжигч (эмнэлгийн ажилтан халуун хэмжихээр зохицуулсан бол шаардлагагүй), эмч мэргэжилтэнтэй холбоо барих утасны жагсаалт, ажиглалтын үед мөрдөх санамж, гал түймэр болон ослын үед ашиглах аврах гарцын бүдүүвч зураг, хориглох зүйлсийн анхааруулга, цэвэрлэгээний зааварчилгаа, хог гаргах цагийн хуваарь.

в/ хаалганы гадна талд хоол, эргэлтийн эд зүйлсийг тавих ширээ (сандал, шүүгээ)

3.7.Энэ журмын 3.6.1-д заасан нөхцөл, шаардлага сум, тосгонд хамаарахгүй байж болно.

3.8.Хэсгийн усан хангамжтай тусгаарлан ажиглах байрны усны эх үүсвэр, ус түгээгүүрийн шугам сүлжээ, ус нөөцлөх санд холбогдох журмын дагуу хамгаалалтын бүс тогтоож, бохирдолтоос хамгаалах арга хэмжээг авч, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангана.

3.9.Зөөврийн усан хангамжтай тусгаарлан ажиглах байрны эх үүсвэрийн ус нөөцлөх савыг сэрүүний улиралд 3 сар, дулааны улиралд сар тутам, ус зөөвөрлөх хадгалах савыг долоо хоногт 2-оос доошгүй удаа угааж цэвэрлэн, халдваргүйжүүлнэ.

3.10.Хувцас тайлах хэсэгт толь, хамгаалах хувцас тайлах дарааллыг харуулсан зурагт хуудас, 50 литрээс дээш хэмжээтэй "Био аюултай" гэсэн тэмдэглэгээтэй шар өнгийн хогийн уут бүхий "хөл ажиллагаа"-тай хогийн сав зэргийг байрлуулсан байх.

3.11.Тусгаарлан ажиглах байрыг халдвартай-"улаан", халдварын эрсдэл дунд буюу завсрын-"шар", халдваргүй-"ногоон" гэсэн гурван бүсээр хуваана.

3.12.Тусгаарлах байрны хяналтын камерны дэлгэцийг тухайн байрны "ногоон бүс"-д байрлуулна.

3.13.Эмч мэргэжилтэн, бусад алба хаагчийн байрлах өрөө, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл тайлах хэсэг, гал тогооноос тусгаарлан ажиглах өрөөнд хоол зөөвөрлөх, хоолны хэрэгслийг гал тогоонд хүргэх болон хог хаягдлыг зөөвөрлөх чиглэл зэрэг орох, гарахыг хориглосон хэсэгт нэг чигийн урсгалаар хөдөлгөөнийг давхцуулахгүй байхаар анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна.

3.14.Тусгаарлан ажиглах байрыг цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах бөгөөд гэрээт харуул хамгаалалт, камерын бүрэн хяналт бүхий тусгаарлан ажиглах байрны гадна орчинд цагдаагийн хамгаалалт гаргахгүй.

Дөрөв. Улсын болон аймаг, сумын онцгой комиссын Шуурхай штабын эрх, үүрэг

4.1.Улсын онцгой комиссын Шуурхай штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Нийслэлд тусгаарлан ажиглах байрны бэлтгэлийг хангуулах;

4.1.2.тусгаарлах байранд ажиллах эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн байгууллагын ажилтны мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн, ажиллах хүчний нөөцийг төлөвлөх;

4.1.3.тусгаарлан ажиглах байранд байгаа хүн /бага насны хүүхэд, тусгай хоолны дэглэмтэй иргэн/-д олгох хоолны жишиг цэсийг хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмжийн хэмжээнд нийцүүлэн мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах бөгөөд тусгаарлан ажиглах байрны менежерт хүргүүлэх;

4.1.4.тусгаарлан ажиглах байрны удирдлага, ажилтан, эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн алба хаагчдад халдвараас сэргийлэх дэглэм, гүйцэтгэх үүрэг, дэг журам сахиулахтай холбоотой сургалтыг сар бүр зохион байгуулж, ажлын хариуцлагад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

4.1.5.авто болон төмөр замын боомтоор татан авах иргэдийн нэрийн жагсаалтыг Монгол Улсаас Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон бусад холбогдох байгууллагаас урьдчилан авах;

4.1.6.гадаад улсаас ирэх иргэн вакцинжуулалтын бүрэн тун авсан эсэх мэдээллийг Дипломат төлөөлөгчийн газар, агаарын тээврийн компани болон автозам, төмөр замын боомтоор орж ирэх үед хил хамгаалах байгууллагаар дамжуулан авах;

4.1.7.гадаад улсаас иргэдийг татан авах ажиллагааны төлөвлөгөөг тухай бүр боловсруулж, батлах;

4.1.8.тусгаарлан ажиглах байрны өрөө, тасалгаа тус бүрийн зай, орны тоог нарийвчлан судалж, иргэдийг байршуулах хуваарийг урьдчилан төлөвлөх ба батлагдсан тохиолдолдын ойрын хавьтал, эрүүл мэндийн байгууллагын ажилчид болон гадаад улсаас ирж байгаа иргэдийг нэг тусгаарлан ажиглах байранд хамтад нь тусгаарлахгүй байх;

4.1.9.тусгаарлан ажиглах байрны онцлог, багтаамж, давхар, өрөө тасалгаа, орны тоо, зохион байгуулалт, иргэний тооноос хамаарч тухайн байранд ажиллах алба хаагчдыг хуваарилах;

4.1.10.гадаад улсаас ирж буй эрүүл мэндийн шалтгаантай зорчигчийг урьдчилан бэлтгэсэн эмнэлэг, бусад зорчигчийг тусгаарлан ажиглах байранд тээвэрлэн хүргэх тээврийн хэрэгслийг бэлтгэх;

4.1.11.тусгаарлан ажиглах байранд зайлшгүй шаардлагаар нэвтрэх ажилтан, албан хаагчдад /төрөлжсөн мэргэшлийн эмч мэргэжилтэн, өргөдөл, гомдлоор шалгалт хийх мэргэжлийн хяналтын улсын байцаагч, хэв журам сахиулах цагдаагийн алба хаагч, тусгаарлах байрны үйлчилгээ, цахилгаан, ус дулаан хангамж, мэдээлэл холбооны г.м/ зөвшөөрөл олгох;

4.1.12.тусгаарлан ажиглах байрны нөхцөл, дэг журам, эрүүл мэнд, хоол хүнсний асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэх;

4.1.13.тусгаарлан ажиглах байрыг орчин нөхцөл, үйлчилгээний чанар, төлбөрийн нөхцөлөөс хамааруулан 3 зэрэглэлд ангилсан судалгаа гаргаж, тусгаарлагдах хүнд санал болгох;

4.1.14.АСШШ-ыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, үүрэг, чиглэл өгч биелэлтийг хангуулах;

4.1.15.удаа дараа зөрчил дутагдал гаргасан аж ахуйн нэгж, байгууллагыг тусгаарлан ажиглах байраар ажиллуулахгүй байх шийдвэрийг гаргаж, гэрээг цуцлах, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх санал гаргах;

4.1.16. тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй онцгой байдлын алба хаагчаас ажиглалт хийж буй иргэний шилжилт хөдөлгөөний тоон мэдээ, эрүүл мэндийн ажилтнаас дэлгэрэнгүй бүртгэлийг өдөр бүр авч нэгтгэн, мэдээллийн санг баяжуулж, дүн шинжилгээ хийх;

4.1.17. тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжих хүний бх-ПГУ шинжилгээний "сөрөг" гарсан сүүлийн хариуг ХӨСҮТ-өөс 11.00 цагаас өмнө албан бичиг эсвэл цахимаар авч, энэ талаар тусгаарлан ажиглах байрны хамгаалалтын ажилтанд мэдэгдэх;

4.1.18. Коронавируст халдвараар өвчилж, эмнэлэгт болон гэрээр эмчлэгдэж эдгэрсэн хүнд тухайн эмнэлгийн болон өрхийн эрүүл мэндийн төв эдгэрсэн талаарх магадлагаа гаргаж өгнө.

4.2. Аймаг, сумын Шуурхай штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1. тусгаарлан ажиглах байрыг энэхүү журмын 3.6-д тавигдах шаардлагад нийцүүлэн сонгох, бэлтгэлийг хангуулах;

4.2.2. байрны онцлог, багтаамж, давхар, өрөө тасалгаа, орны тоо, зохион байгуулалт, иргэний тооноос хамаарч тухайн байранд ажиллах алба хаагчдыг хуваарилах;

4.2.3. тусгаарлан ажиглах байрны удирдлага, ажилтан, алба хаагчдад сургалт зохион байгуулж, мэдээллээр хангах;

4.2.4. сэжигтэй тохиолдол болон эрүүл мэндийн шалтгаантай зорчигчийг эрүүл мэндийн байгууллагад, бусад зорчигчийг урьдчилан бэлтгэсэн тусгаарлан ажиглах байранд тээвэрлэн хүргэх тээврийн хэрэгслийг бэлтгэх;

4.2.5. тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжих иргэнийг халдвараас сэргийлэх дэглэм, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж тээвэрлэх ажлыг зохион байгуулах;

4.2.6. хилийн боомтоор нэвтэрсэн хүнийг тухайн нутаг дэвсгэрт тусгаарлах арга хэмжээг зохион байгуулах.

Тав. Хилийн нэвтрэх цэгт авч хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. УОКШШ-аас ирүүлсэн нэрсийн жагсаалтын дагуу улсын хилийн боомтоор татан авч буй зорчигчдыг тусгаарлан ажиглалтад шилжүүлэх, эрэмбэлэн ангилах төлөвлөлтийг хилийн мэргэжлийн хяналтын алба хийнэ.

5.2. Хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсээс сэжигтэй зорчигчийн мэдээллийг нийслэлд ХӨСҮТ, орон нутагт Эрүүл мэндийн байгууллагад өгнө.

5.3. Зорчигчдод эрүүл мэндийн тандалт судалгаа хийж, эрэмбэлэн ангилна.

5.4. Зорчигчийн ачаа, гар тээшийг тусгайлан бэлтгэсэн байранд мэргэжлийн байгууллага халдваргүйжүүлнэ.

5.5. Хил хамгаалах байгууллагын ажилтан нь халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зорчигчийн биеийн байцаалтыг шалган, улсын хилээр нэвтрэх зөвшөөрөл олгоно.

5.6. Халдварын сэжигтэй зорчигчийг бусад зорчигчоос түр тусгаарлан, ойрын хавьтлуудын хамт эрүүл мэндийн байгууллагын шуурхай хариу арга хэмжээний багт тэмдэглэл үйлдэн шилжүүлнэ.

5.7. Шуурхай штабаас урьдчилан ирүүлсэн нэрсийн жагсаалтын дагуу бусад зорчигчийг тээврийн хэрэгсэлд суулгаж цагдаагийн хамгаалалтад шилжүүлнэ.

5.8. Агаарын тээврийн компаниуд нь гадаад улсаас ирэх иргэний дархлаажуулалтын бүрэн тун авсан эсэх мэдээллийг УОК-ын Шуурхай штабт хүргүүлнэ.

5.9. Монгол Улсад ажиллах нөхцөлтэйгээр болон урилгаар ирж байгаа гадаад иргэний шинжилгээний төлбөрийг тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

Зургаа. Тусгаарлан ажиглах байр (хуулийн этгээд), түүнд ажиллагсдын үүрэг

6.1. Тусгаарлан ажиглах байрыг хариуцаж буй хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

6.1.1. тусгаарлагдах хүмүүсийн мэдээллийг улсын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Шуурхай штабаас урьдчилан авч, тусгаарлан ажиглах байрыг бэлтгэж, бэлэн байдлыг хангах;

6.1.2. тусгаарлан ажиглах байрны байршил, давхар, өрөө, тасалгаа, нийт орны тоогоор зураглал гаргаж улсын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Шуурхай штабт хүргүүлэх;

6.1.3. тусгаарлан ажиглах байрны цахилгаан, халаалт, усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цуглуулалт, зайлуулалтын тасралтгүй байдлыг хангах;

6.1.4. тусгаарлагдсан хүн, ажиллагсдын хоол, хүнсний нийлүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт, үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавьж, хоол, хүнс, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангах, ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах;

6.1.5. улсын бүртгэлд бүртгэгдсэн, хаяг шошгын зөрчилгүй, хэрэглэх заавар тодорхой халдваргүйжүүлэх бодисоор батлагдсан зааврын дагуу угаалга, цэвэрлэгээг тогтмол хийх;

6.1.6. тусгаарлах байранд ажиллах ажилтнуудын хувийн бэлтгэлийг бүрэн хангуулж, ээлж солихгүйгээр ажиллуулах;

6.1.7. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг болон бх-ПГУ шинжилгээнд бүрэн хамрагдсан тогооч, ажилтныг ажиллуулна. Хэрэв вакцинжуулалтын бүрэн тун хийлгэж, 14 хоногийн хугацаа өнгөрсөн, сүүлийн 4 сарын дотор өвчлөөд эдгэрсэн бол бх-ПГУ шинжилгээ шаардахгүй.

6.1.8. тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэх эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

6.1.9. тусгаарлан ажиглах байранд сэжигтэй тохиолдол илэрсэн үед хэрэглэх иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, N95 амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий, малгай, гутлын гадуурх улавч зэрэг)-ийн нөөцийг бэлтгэх;

6.1.10. тусгаарлан ажиглалтад байгаа иргэний мэдээлэл, хувь хүний нууцыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас бусдад задруулахгүй байх;

6.1.11. тусгаарлагдсан хүн гарсны дараа байр, өрөөнд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж дараагийн хүнийг хүлээн авах бэлтгэлийг хангах;

6.1.12. нэг ээлжийн тусгаарлан ажиглалтын хугацаа дуусмагц 2 хоногийн дотор хяналтын камерын бичлэгийн хуулбарыг тагнуул, цагдаагийн байгууллагад шилжүүлэх.

6.2. Тусгаарлан ажиглах байрны гал тогооны ажилтан дараах үүрэг хүлээнэ:

6.2.1. шуурхай штабаас боловсруулсан жишиг цэсэд нийцүүлэн 7 хоногийн хоолны цэс, технологийн картыг боловсруулж, байгууллагын удирдлагаар батлуулж, мөрдөж ажиллах;

6.2.2. хоол үйлдвэрлэлийг явуулахдаа эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг сайтар хангах;

6.2.3. эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой, баталгаажилттай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хоол үйлдвэрлэлд ашиглаж, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг тогтмол хөтлөх;

6.2.4. бэлтгэсэн хоол, хүнсний цуврал бүрээс 150 гр-аас доошгүй дээжийг ариутгасан саванд авч битүүмжлэн хаяглаж, 4°C-ийн хэмд, 72 цагаас багагүй хугацаанд хадгалж, бүртгэл хөтөлсний дараа устгах;

6.2.5. хоолны сав, хэрэгслийг 2 хувийн содын уусмал эсвэл зориулалтын угаагч бодисоор цэвэрлэж, халдваргүйжүүлэх;

6.2.6. хоолыг зориулалтын халуун баригч бүхий битүүмжлэлтэй саванд хийж, зөөвөрлөх;

6.2.7. хоол зөөх тэргэнцэрийг 0.015 хувийн жавелион эсвэл хлор агуулсан бусад бодисоор тогтмол халдваргүйжүүлэх;

6.2.8.тусгаарлах байранд ажиллаж буй бусад албан хаагч, ажилтантай шууд харьцахгүй, гал тогооноос бусад хэсэгт зорчихгүй байж, халдвараас сэргийлэх дэглэмийг чанд мөрдөх;

6.2.9.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 6 сар тутамд бүрэн хамрагдах;

6.2.10.өөрийн эрүүл мэндийн байдал, биеийн халуунд өдөр бүр хяналт тавьж, өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тусгаарлах байрны эмч мэргэжилтэнд яаралтай мэдэгдэх.

6.3.Тусгаарлан ажиглах байрны үйлчилгээний ажилтан дараах үүрэг хүлээнэ:

6.3.1.халдваргүйжүүлэх бодисыг найруулах арга, хэрэглээний талаарх сургалтад хамрагдах;

6.3.2.тусгаарлан ажиглалтад байгаа хүн шал болон бусад гадаргуу дээр бөөлжсөн, суулгасан тохиолдолд шингэнийг нэг удаагийн цаасан алчуураар шингээж авах, бүхэл хэсгийг хутгуур ашиглан хамж авсны дараа угаалгын бодистой халуун усаар угааж цэвэрлэн шалыг 0.015 хувь, ариун цэврийн өрөөг 0.03 хувийн жавелионы уусмал эсвэл хлор агуулсан бусад бодисоор халдваргүйжүүлэх;

6.3.3.цэвэрлэгээ, үйлчилгээ хийх, хог хаягдал цуглуулах үедээ нэг удаагийн халат, малгай, нүдний шил эсвэл нүүрний хаалт, нэг удаагийн амны хаалт хэрэглэх, нэг удаагийн бээлий дээр цэвэрлэгээний зузаан бээлий өмсөх;

6.3.4.хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөхийн өмнө, тайлсны дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, хоол идэхийн өмнө, цэвэрлэгээ, үйлчилгээ хийсний дараа гараа тогтмол угааж халдваргүйжүүлэх;

6.3.5.өрөөний үүдэнд гаргасан хатуу хог хаягдлыг тогтоосон цагийн хуваарийн дагуу цуглуулж, хог хаягдлын цэгт хүргэх;

6.3.6.халдвартай хог хаягдлыг шар өнгийн уутанд цуглуулан зөөвөрлөн түр хадгалах хэсэгт хүргэх, цэвэрлэгээ, үйлчилгээний дараа хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу тайлах;

6.3.7.тусгаарлан ажиглах өрөөний хаалганы гадна талын бариул, хонх, коридорын шал, явган хүний болон цахилгаан шат зэрэг хүний гар байнга хүрэлцэх гадаргууг өдөр бүр цэвэрлэж, халдваргүйжүүлэх;

6.3.8.цахилгаан шат, хаалганы дээд хэсэг, коридорын болон хүлээлгийн танхимын гар хүрэхгүй хэсгийг зориулалтын бодисоор шүршиж халдваргүйжүүлэх;

6.3.9.хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг тайлахгүйгээр өөрийн амрах байр болон бусад хэсгүүдэд зорчихгүй байх.

6.4. Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтан дараах үүрэг хүлээнэ:

6.4.1.ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акттай урьдчилан танилцаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

6.4.2.тусгаарлан ажиглах байрны өрөө, орны тоо, хуваарилалтад хяналт тавьж байршлаар нарийвчлан гаргасан судалгааны дагуу иргэнийг байрлуулах, халдвараас сэргийлэх дэглэмийг дагаж мөрдөх талаар заавар, зөвлөмж өгч тэмдэглэл үйлдэх;

6.4.3.ажиллаж буй төрийн албан хаагч болон ажилтнуудад халдвараас сэргийлэх дэглэмийн зааварчилгаа өгч, удирдан зохион байгуулах;

6.4.4.тусгаарлан ажиглах байранд байгаа иргэнд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн анхны яаралтай тусламж үзүүлсэн бол "яаралтай тусламжийн хуудас"-ыг хөтлөн, эм, эмнэлгийн хэрэгслийн зарлагыг тухай бүр бүртгэнэ.

6.4.5.тусгаарлагдсан хүнээс батлагдсан загварын дагуу "Эмнэлзүйн шинж тэмдэг тандах хуудас" бөглүүлж авах;

6.4.6.тусгаарлан ажиглалтад байгаа хүний биеийн халууныг өдөрт 2-оос доошгүй удаа хэмжиж, эмнэл зүйн шинж тэмдэг илэрч байгаа эсэх тухай тэмдэглэл хөтлөх;

6.4.7.өөрийн болон бусад (үйлчилгээний болон онцгой байдал, цагдаагийн) алба хаагчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, өдөр бүр биеийн халууныг хэмжиж, эмнэл зүйн шинж тэмдэг илэрч байгаа эсэх тухай тэмдэглэл хөтлөх;

6.4.8.тусгаарлан ажиглах байр болон өрөөнд зайлшгүй шаардлагаар нэвтэрч байгаа эмч мэргэжилтэн, бусад ажилтны талаарх мэдээллийг тухай бүр бүртгэж, тэмдэглэл хөтлөх;

6.4.9.хоол түгээх, биеийн халуун хэмжих, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үед нэг удаагийн халад, малгай, эмнэлгийн амны хаалт, үзлэгийн бээлий, гутлын гадуурх улавч хэрэглэх;

6.4.10.коронавируст халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, N95 амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий, малгай, гутлын гадуурх улавч зэрэг)-ийг өмсөж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

6.4.11.тусгаарлагсдын хоол, цайг гал тогооноос хүлээн авч, ажиглалтын өрөөний үүдэнд байрлуулсан ширээн дээрх аяга, тавагны гадаргууд бээлийтэй гараар хүрэхгүйгээр хоолыг хийж түгээх;

6.4.12.хоол түгээж дууссаны дараа хоолны сав, хэрэгслийг гал тогооны бохир хүлээн авах хэсэгт хүргэх;

6.4.13.тусгаарлалтад байгаа хүнд ямар нэгэн зовуур, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн үед үзлэг хийж, тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үнэлэх;

6.4.14.тусгаарлалтад байгаа хүнд эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол харьяалах эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэж, яаралтай тусламж үзүүлэх;

6.4.15.тусламж, үйлчилгээ үзүүлсний дараа хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу зөв тайлж, халдвартай хог хаягдлыг шар өнгийн уутанд цуглуулах;

6.4.16.хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөхийн өмнө, тайлсны дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, хоол идэхийн өмнө гарыг тогтмол угааж, халдваргүйжүүлэх;

6.4.17.тусгаарлан ажиглалтад байгаа хүн заналхийлэх, доромжлох, тавьсан шаардлагыг эсэргүүцэх, биед халдах зэрэг үйлдэл гаргасан тохиолдолд онцгой байдал болон цагдаагийн алба хаагчид нэн даруй мэдэгдэх;

6.4.18.тусгаарлан ажиглалтад байгаа хүний овог, нэр, нас, хүйс, аяллын товч түүх, холбоо барих утас, оршин суугаа гэрийн хаяг, тусгаарлалтад орсон, шилжсэн, гарсан огноо, эрүүл мэндийн мэдээлэл зэргийг УОК-ын Шуурхай штаб, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Шуурхай удирдлагын нэгжийн Google.sheet файлын "Нэмэлт мэдээлэл" талбарт 24 цагийн дотор байршуулах;

6.4.19.тусгаарлан ажиглах байрнаас гэрийн ажиглалтад шилжиж буй хүнд гэрийн ажиглалтад мөрдөх дэглэм, журмыг танилцуулж, баталгааны хуудсыг тухайн хүнээр 2 хувь үйлдүүлж, 1 хувийг өөрт нь, нөгөө хувийг цагдаагийн алба хаагчид хүлээлгэж өгөх.

6.5.Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй Онцгой байдлын алба хаагч дараах үүрэг хүлээнэ:

6.5.1.дотоод үйл ажиллагаанд камерын хяналт тавьж, 24 цагийн турш аюулгүй байдлыг хангах;

6.5.2.хүний эрүүл мэнд, амь насанд аюултай нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллах ба эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд цагдаагийн байгууллагын алба хаагчтай хамтран ажиллах;

6.5.3.галын аюулгүй байдал, аврах зам, гарцын тэмдэг, тэмдэглэгээ, хэвийн ажиллагаанд хяналт тавих;

6.5.4.тусгаарлалтад байгаа хүнд ирсэн эргэлтийн эд зүйлсийг дундын бүс /шар/-ээс авч, эмч мэргэжилтэнд хүлээлгэж өгөх;

6.5.5.шилжилт хөдөлгөөний мэдээг тухай шатны онцгой комиссын Шуурхай штабт өдөр бүр хүргүүлэх;

6.5.6. тусгаарлан ажиглах хүнийг хүлээн авч, байрлуулахад эмч мэргэжилтэнд дэмжлэг үзүүлэх, иргэний санал, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч, тэмдэглэл хөтлөн шийдвэрлүүлэх;

6.5.7. үүрэг гүйцэтгэх хугацаанд өдөр бүр гарсан зөрчил, дутагдлын талаар холбогдох мэдээг УОК-ын Шуурхай штабт 10:00 цаг, 18:00 цаг, 24:00 цагт өгч, тэмдэглэл хөтлөх.

6.6. Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй цагдаагийн алба хаагч дараах үүрэг хүлээнэ:

6.6.1. гадна орчинд хамгаалалтын бүс тогтоож, тэмдэг тэмдэглэгээг нийтэд харагдахуйц байдлаар байршуулан, хэв журам сахиулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгслийг хамгаалж байгаа объект, бүсэд нэвтрүүлэхгүй байх;

6.6.2. байрны дотоод орчинд камерын хяналт тавьж дэг журмыг сахиулах;

6.6.3. байранд нэвтрэх шаардлагатай эмч мэргэжилтэн, эрх бүхий байгууллагаас зөршөөрөлтэй албан хаагчийн ажлын үнэмлэх, хүчин төгөлдөр "ПГУ/PCR" шинжилгээний хариуг шалгаж, бүртгэл хөтлөн нэвтрүүлэх;

6.6.4. тусгаарлан ажиглах байранд хориглосон эд зүйлсийг нэвтрүүлэхгүй байх зорилгоор ачаа тээш, эд зүйлсэд үзлэг хийж гэрчээр онцгой байдлын алба хаагчийг байлцуулан тэмдэглэл хөтлөх;

6.6.5. энэхүү журмаар хориглосон эд зүйлсийг тусгаарлан ажиглах байранд нэвтрүүлэхгүй байх бөгөөд буцаах боломжгүй бол бүртгэл хөтлөн түр хадгалж, тусгаарлалтаас гарах үед эзэнд нь хүлээлгэн өгөх;

6.6.6. тусгаарлагдаж байгаа хүнд болон үүрэг гүйцэтгэж буй бусад албан хаагчдад хууль ёсны шаардлага тавьж, гарсан гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, энэ талаар тэмдэглэл үйлдэн нэн даруй удирдах албан тушаалтанд мэдэгдэж, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх;

6.6.7. хамгаалалтын бүсэд үүрэг гүйцэтгэх хугацаанд өдөр бүр Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай штабт 10:00, 18:00, 24:00 цагт мэдээ өгч, тэмдэглэл хөтлөх;

6.6.8. гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын эрх бүхий дипломат ажилтныг тусгаарлах тохиолдолд "Дипломат харилцааны тухай Венийн конвенц"-ийн 36 дугаар зүйлд заасныг баримтлах;

6.6.9. энэхүү журмын 6.6.8-д заасан хүний биед болон түүний ачаа тээшинд үзлэг хийх тохиолдолд Монгол Улсын Гадаад харилцааны яаманд мэдэгдэж, тухайн дипломат ажилтныг харьяалах Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, эсхүл түүний бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулах.

6.7. Тусгаарлан ажиглах байранд байрлах этгээд дараах үүрэг хүлээнэ:

6.7.1. хуваарилсан өрөөнд байрлаж, тусгаарлалтын дүрэм, журмыг мөрдөх;

6.7.2. тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй албан хаагчдын хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

6.7.3. тусгаарлан ажиглах байранд орохоос өмнө өөрийн эрүүл мэнд байдал, шашны зан үйлээр хориглосон болон харшлах, эм, эмийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээллийг урьдчилан мэдэгдэх;

6.7.4. тусгаарлан ажиглалтын хугацаанд "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын лабораторийн оношилгооны түр заавар"-т тусгасан сорьц цуглуулах давтамжийн дагуу шинжилгээнд хамрагдах;

6.7.5. өөрийнхөө эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, коронавируст халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд энэ талаар нэн даруй мэдэгдэх;

6.7.6. бусдын амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байж, эмч мэргэжилтэн болон бусад хүнтэй харьцах үедээ амны хаалт хэрэглэж, хүн хоорондын зайг барих;

6.7.7. өрөөний цонхны салхивчийг 2 цаг тутамд 15 минут нээж, агааржуулалт хийж, зааврын дагуу гараа тогтмол угааж, хувийн ариун цэврийг сахих

6.7.8.зааварчилгааны дагуу өрөөний цэвэрлэгээг өдөр тутам хийж, ахуйн хог хаягдлыг хуваарийн дагуу өрөөний үүдэнд гаргаж тавих;

6.7.9.байрны эд хогшлыг зориулалтын дагуу, ариг гамтай ашиглах, тухайн байгууллагын дотоод журамтай танилцаж гарын үсэг зурах;

6.7.10.гадаад улсаас татан авалтаар ирэх хүн тусгаарлан ажиглах байрны нөхцөл, тавих шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тарифын дагуу байрны төлбөрийг урьдчилан төлөх;

6.7.11.коронавируст халдвартай болох нь батлагдсан тохиолдолд өөрийн уулзсан хүн, явсан зам, чиглэлийн талаарх мэдээллийг үнэн зөв мэдээлэх, эмнэлэг болон эмнэлгийн зориулалтаар ашиглах байранд эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах;

6.7.12.бага насны хүүхэдтэй тусгаарлагдсан тохиолдолд түүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хариуцах;

6.7.13.тусгаарлан ажиглах байрнаас гарах үед өөрийн ачаа тээшийн гадаргууг халдваргүйжүүлэх бодис бүхий уусмалаар арчиж халдваргүйжүүлэх.

6.7.14.ар гэрээс нь эргэлт өгөх боломжгүй үед тусгаарлан ажиглах байрны эрх бүхий ажилтанд хүсэлт гаргаж зөвшөөрөгдсөн эд зүйлсийг худалдан авч болно.

6.8.Тусгаарлан ажиглалтад байгаа хүнд дараах үйлдлийг хориглоно:

6.8.1.ажилтан, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, доромжлох, заналхийлэх, биед нь халдах, аливаа зүй бус үйлдэл гаргах;

6.8.2.бусдын эрүүл мэндэд хохирол учруулахуйц хурц үзүүртэй эд зүйл, архи, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, халуун бууруулах, өвчин намдаах эм, эмийн хэрэгсэл, бодис, түргэн гэмтэж, муудах хүнсний бүтээгдэхүүн, олон хүн тоглох тоглоом /хөзөр, хөлөгт тоглоом гэх мэт/ зэргийг авч орох, хэрэглэх, эргэлтээр авах;

6.8.3.өрөөнөөс гарах, өрөөний цонхоор хог, тамхины иш, нус, цэр, шүлсээ хаях болон эд зүйл дамжуулах, бусадтай харилцах;

6.8.4.бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, өдөөн турхирах, буруу ташаа мэдээлэл тараах.

Долоо.Тусгаарлан ажиглах байранд эргэлт оруулах ажиллагаа

7.1.Тусгаарлан ажиглах байранд байгаа хүнд энэ журмын 7.2-т заасан хориглоогүй эд зүйлсийг долоо хоногт нэг удаа эргэлтээр оруулж болно.

7.2.Тусгаарлан ажиглах байранд байгаа хүнд цагаан хэрэглэл, ахуйн болон ариун цэврийн хэрэглэл (шүдний оо, сойз, шампунь, ангижруулагч, саван, гоо сайхны бүтээгдэхүүн, алчуур, ариун цэврийн цаас, живх, амны хаалт, гар халдваргүйжүүлэгч бодис) хувцас, гутал, бичгийн хэрэгсэл, ном, сонин, сэтгүүл, гар утас, сим карт, нэгж, компьютер, техник хэрэгсэл, хүүхдийн тоглоом, чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан, зориулалтын савлагаатай, бүрэн бүтэн байдал нь алдагдаагүй, хүнсний бүтээгдэхүүн (талх, нарийн боов, чихэр, цай, кофе, ёотон, сүү, тараг, жимс, хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл хүнс г.м.) хүүхдийн угж, хооллох хэрэгсэл зэргийг гэрэлтдэг уутанд хийж, эд, зүйлсийн жагсаалт, тоо ширхэгийг бичиж оруулахыг зөвшөөрнө.

7.3.Эргэлтийг 10:00-16:00 цагийн хооронд тусгаарлан ажиглах байрны тогтсон нэг хаалгаар хүлээн авна.

7.4.Эргэлтийг эмч мэргэжилтэн, албан хаагчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулна.

7.5.Эргэлтийн эд зүйлийг цагдаагийн алба хаагч “ногоон” бүсэд хүлээн авч, үзлэг хийн зөвшөөрөгдсөн эд, зүйлсийг завсрын буюу “шар” бүсэд хүргэх бөгөөд энэ журмын 6.8.2-т заасан хориглосон эд зүйлсийг буцаана.

7.6.Цагдаагийн албан хаагч дундын бүсэд эд зүйлсийг байршуулсны дараа онцгой байдлын алба хаагч хүлээн авч “улаан” бүсэд эмч мэргэжилтэнд дамжуулан өгнө.

7.7.Тусгаарлан ажиглах байранд энэ журмын 6.8.2-т заасан эд зүйлийг оруулахыг хориглоно.

Найм. Тусгаарлан ажиглах байранд сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрсэн үеийн хариу арга хэмжээ

8.1.Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдсан хүнд коронавируст халдварын шинж тэмдэг илэрсэн үед хугацаа харгалзахгүй антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ ажлыг нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/-ийн шуурхай хариу арга хэмжээний баг, орон нутагт харьяа Эрүүл мэндийн байгууллага зохион байгуулна.

8.2.Нэг өрөөнд тусгаарлагдсан 0-16 насны хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн аль нэгээс коронавируст халдвар батлагдсан тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зөвшөөрлийн дагуу эрүүл мэндийн байгууллагад хамтад нь шилжүүлж болно.

8.3.Нэг өрөөнд тусгаарлагдсан гэр бүлийн болон хамт амьдарч, ажиллаж, сурч байсан хүмүүсээс сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрвэл тухайн хүнийг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж, бусад иргэнийг өрөөнд нь тусгаарлан эсэхийг тандалтын багийн дүгнэлтийг үндэслэн тухайн шатны онцгой комиссын Шуурхай штаб шийдвэрлэнэ.

8.4.Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх үед тухайн нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж, хяналт хийлгэнэ.

8.5.Халдваргүйжүүлэлт хийсэн хэсгүүдийг зааврын дагуу угааж цэвэрлэнэ.

8.6.Тусгаарлан ажиглах байрны эрүүл мэндийн ажилтан нь батлагдсан болон сэжигтэй тохиолдлоор эмнэлгийн байгууллага руу хүргэгдсэн хүний мэдээллийг 1 цагийн дотор улсын болон нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабт тус тус мэдэгдэнэ.

8.7.Ганцаараа тусгаарлагдах боломжгүй /өөрийн үйлдлийг хянах чадваргүй, бүрэн бус чадвартай, хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй, бага насны хүүхэд/ хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тусгаарлах байр руу оруулж, хамтад нь тусгаарлаж болно.

8.9.Батлагдсан тохиолдлын эмнэлзүйн хэлбэрийг харгалзан эмнэлэг эсвэл гэрт нь тусгаарлан эмчилнэ.

8.10.Тусгаарлах байранд батлагдсан тохиолдлыг ХӨСҮТ-ийн болон орон нутгийн Шуурхай хариу арга хэмжээний баг тээвэрлэнэ.

Ес. Тусгаарлан ажиглах байрны халдваргүйжүүлэлт

9.1.Урьдчилан сэргийлэх буюу өдөр тутмын халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын гаргасан заавар журмын дагуу хийж гүйцэтгэх.

9.2.Тусгаарлалтын нэг ээлж дууссаны дараах халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.3.Тусгаарлан ажиглалтад орж байгаа хүнийг тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг мэргэжлийн байгууллага халдваргүйжүүлнэ.

9.4.Тусгаарлан ажиглах байрнаас коронавируст халдварын батлагдсан тохиолдлыг шилжүүлсэний дараа тухайн хүний байрлаж байсан өрөө, ажилтны амралтын өрөө, явсан чиглэлийн дагуу коридор, шат, лифт, хаалганы хэсэгт голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг нийслэлд ЗӨСҮТ, холбогдох мэргэжлийн байгууллага, аймагт ЗӨСТ, ЗӨСТ-гүй аймагт Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум, тосгонд эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг гүйцэтгэнэ.

Арав. Тусгаарлан ажиглах байранд тавих хөндлөнгийн хяналт

10.1.Мэргэжлийн хяналтын байгууллага нь тусгаарлан ажиглах байранд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

10.1.1.тусгаарлан ажиглах байрны эрүүл ахуйн нөхцөл, халдвараас сэргийлэх дэглэм, хоол хүнсний аюулгүй байдлын талаар ирүүлсэн өргөдөл гомдол, удирдлагын шийдвэрийн дагуу болон явцын хяналт шалгалтыг хийж, зөрчил, дутагдлыг илрүүлэх, шалтгаан нөхцөлийг тогтоож, холбогдох арга хэмжээг авах;

10.1.2.тусгаарлан ажиглах байранд хийж байгаа халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээнд хяналт тавих;

10.1.3. батлагдсан болон сэжигтэй тохиолдол илэрсэн үед хийх голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хяналт тавих.

10.2. Шаардлагатай тохиолдолд тусгаарлан ажиглах байрны хөндлөнгийн хяналтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тагнуул, цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

10.3. Тусгаарлан ажиглах байранд хяналт тавих этгээд шаардлагатай тохиолдолд камерын бичлэгийг ашиглана.

Арван нэг. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах ажиллагаа

11.1. Тусгаарлан ажиглах байр, өрөө, хоол үйлдвэрлэл, харуул, үйлчилгээ, хяналтын ажилтны хэсгээс гарах ариун цэврийн цаас, шил, лааз, сав, хайрцаг зэрэг баглаа боодол, хүнсний ногооны хальс, хоолны үлдэгдлийг энгийн хог хаягдлын хар өнгийн уутанд цуглуулна.

11.2. Тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэж байгаа эмч мэргэжилтэн, алба хаагч болон бусад ажилтны хэрэглэсэн хамгаалах хувцас, хэрэгсэл (нэг удаагийн амны хаалт, бээлий, халат, нүдний шил, нүүрний хаалт, малгай, гутлын улавч болон тарианы хөвөн, дуслын системийн зүүгүй хэсэг, живх зэрэг)-ийг шар өнгийн уутанд цуглуулна.

11.3. Тусгаарлан ажиглах байранд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн болон гэрийн нөхцөлд эмчилгээ хийлгэхэд хэрэглэсэн тарианы ампул, зүү, тариур зэрэг хурц үзүүр, иртэй хог хаягдлыг аюулгүй хайрцагт цуглуулна.

11.4. Халуун хэмжигч багажийн зай, өдрийн гэрэл, даралт хэмжигч зэрэг хүнд металл агуулсан, хугацаа дууссан, хагарч гэмтсэн, бохирдсон эм, халдваргүйжүүлэх бодис агуулсан сав зэргийг хүрэн өнгийн уутанд цуглуулна.

11.5. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан шар, хүрэн өнгийн ууттай болон аюулгүй хайрцагтай хог хаягдлыг өдөрт 1 удаа тухайн байрны хог хаягдал цуглуулах цэгт төвлөрүүлнэ.

11.6. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан ахуйн хог хаягдлыг энгийн хог хаягдлын журмаар цуглуулж, хадгалан тээвэрлэж устгана.


11.7. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан аюултай хог хаягдлыг нийслэлд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага, орон нутагт тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллага авна.

Арван хоёр. Бусад.

12.1. Ажил үүргийн хувьд олж мэдсэн хувь хүний нууцыг албан тушаалтан задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

12.2. Энэхүү түр журмыг зөрчсөн албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд Гамшгаас хамгаалах тухай хууль, "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийг үндэслэн Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэний тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг
зохицуулах түүр журмын хавсралт



ТУСГААРЛАГДСАН ИРГЭНИЙ СУДАЛГААНЫ ХҮСНЭГТ

Тусгаарлах байрны нэр:

Тусгаарлах байрны хаяг:

| № | Овог, нэр | Нас | Хүйс | Регистрийн дугаар | Иргэний үнэмлэхийн хаяг | Оршин суух буюу тусгаарлалтад байх хаяг | Байнга ашиглах утасны дугаар/суурин болон гар утас | Шаардлагатай үед холбоо барих хүний нэр, утасны дугаар | Тусгаарлан ажиглах байр | | Гэртээ тусгаарлах боломжтой эсэх |
|---|-----------|-----|------|-------------------|-------------------------|---|--|--|-------------------------|-------------|----------------------------------|
| | | | | | | | | | Орсон огноо | Гарах огноо | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |

Жич: Гэртээ тусгаарлах боломжтой эсэхийг асууж тодруулан /нялх хүүхэдтэй, өндөр настантай, ам бүл олуулаа болон бусад/ иргэн өөрийн хүсэлтээр тухайн байранд тусгаарлалтыг үргэлжлүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Улсын онцгой комиссын даргын 2021 оны
43 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ГЭРИЙН АЖИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журмын зорилго нь гэрийн тусгаарлан ажиглалтын үйл ажиллагааг зохион байгуулах, халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлэх, иргэн, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход оршино.

1.2. Гэрийн ажиглалт (цаашид “гэрийн тусгаарлалт” гэх) гэдэг нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан (цаашид “батлагдсан тохиолдол” гэх) тохиолдлын ойрын хавьтал, тусгаарлан ажиглах байрнаас гарсан, халдварын улмаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч эдгэрсэн, эсхүл голомттой орон нутгаас болон голомттой орон нутаг хооронд зорчсон хүнийг орон байр, гэр, сууцанд нь ажиглаж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хяналтад байлгахыг хэлнэ.

1.3. Аж ахуйн нэгж, байгууллагын нэг ээлжийн ажилчдыг тусгайлан бэлдсэн байр (зочид буудал, ажилчдын амрах байр зэрэг)-нд тусгаарлан ажиглалтыг тухайн байгууллагын хяналтад байлгах бөгөөд гарах бүх зардал, үйлчилгээг тухайн аж ахуйн нэгж бүрэн хариуцна.

1.4. Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг улсын хэмжээнд Улсын онцгой комиссын Шуурхай штаб, орон нутаг аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын Шуурхай штаб нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

1.5. Гэрийн ажиглалтыг хянах үйл ажиллагааны баримт бичгийг хуулийн этгээд бусдад шилжүүлэх, дамжуулахдаа цахим гарын үсэг хэрэглэнэ.

1.6. Иргэнийг гэр ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах үед дараах зарчмыг баримтална:

1.6.1. хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;

1.6.2. хууль дээдлэх, хүний эрхийг хангах;

1.6.3. шуурхай ил тод байх;

1.6.4. хувь хүний нууцыг чанд хадгалах.

1.7. Гэрийн ажиглалтад байгаа хүний эрүүл мэндийн хяналтыг дүүрэг, өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтэн, ажиглалтын дэглэмийн мөрдөлт, дэг журмыг сум, дүүрэг, хороо, багийн цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтан хариуцна.

Хоёр. Гэрийн ажиглалтын хугацаа, шинжилгээ

2.1. Дараах тохиолдолд хүнийг гэрээр 14 хоног ажиглана:

2.1.1. батлагдсан тохиолдлын ойрын хавьтал;

2.1.2. халдвар бүртгэгдсэн бүс, орон нутгаас халдвар бүртгэгдээгүй бүс, орон нутагт зорчиж буй хүн;

2.2. Дараах тохиолдолд хүнийг гэрээр 7 хоног тусгаарлан ажиглана:

2.2.1. тусгаарлагдах хугацаа дуусаж тусгаарлан ажиглах байрнаас гарсан хүн;

2.2.2. тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэх үед батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй бол төрийн албан хаагч, тусгаарлах байрны ажилчид (антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээгээр “сөрөг” хариу гарсан);

2.2.3. коронавируст халдварын улмаас эмчлэгдэж эдгэрэн эмнэлгээс гарсан хүн.

2.2.4. халдвар бүртгэгдсэн бүс, орон нутаг хооронд зорчиж буй хүн;

2.3. Гэрийн ажиглалтад байгаа хүнээс 6 дахь хоногт бх-ПГУ шинжилгээг авах ажлыг нийслэлд дүүргийн эрүүл мэндийн төвийн баг, орон нутагт харьяа Эрүүл мэндийн байгууллага зохион байгуулна. Ажиглах хугацаанд халдварын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн даруйд антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ хийж, сөрөг гарвал бх-ПГУ шинжилгээнд хамруулна.

2.4. Тусгаарлагдсан иргэнд шаардлагатай тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллага гэрийн тусгаарлан ажиглалтад байсан тухай тодорхойлолт олгож болно.

2.5. Дараах хүн, албан тушаалтныг гэрийн ажиглалтад шилжүүлэхгүй:

2.5.1. сүүлийн 4 сарын хугацаанд коронавируст халдвараар өвчилж эдгэрсэн, вакцинжуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн;

2.5.2. халдваргүй бүс нутгаас зорчиж буй хүн,

2.5.3. эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ авахаар зорчиж буй иргэн, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч;

2.5.4. төрийн болон онцгой нөхцөл шаардлагаар албан томилолтоор зорчиж буй иргэн, албан хаагч, ажилтан;

2.6. Гэрийн ажиглалтад орохгүй хүн вакцинжуулалтын бүрэн тунд хамрагдсан, эмчлүүлж эдгэрсэн талаарх нотлох баримтыг үнэн зөв гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

2.7. Коронавируст халдвараар өвчилж, эмнэлэгт болон гэрээр эмчлэгдэж эдгэрсэн хүнд тухайн эмнэлгийн болон өрхийн эрүүл мэндийн төв эдгэрсэн талаарх магадлагаа гаргаж өгнө.

Гурав. Иргэний эрх, үүрэг

3.1. Гэрийн ажиглалтад байх иргэн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. оршин суух буюу өөрийгөө тусгаарлах хаяг байршил, мэдээллээ бүртгүүлэх, тухайн хаяг, байршилдаа энэхүү журмын 2.1, 2.2-т заасан хугацаанд гэрээс гарах болон зорчих хөдөлгөөн хийхийг хориглоно;

3.1.2. аймаг, нийслэл, сум, дүүргийн Шуурхай штаб, гэрийн тусгаарлалтад хяналт тавих үүрэг хүлээсэн засаг захиргааны анхан шатны нэгжид ажиллаж буй ажилтан, албан хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

3.1.3. гэрийн ажиглалтын хугацаанд "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын лабораторийн оношилгооны түр заавар"-т тусгасан сорьц цуглуулах давтамжийн дагуу шинжилгээнд хамрагдах;

3.1.4. коронавируст халдвартай болох нь батлагдсан тохиолдолд өөрийн уулзсан хүн, явсан зам, чиглэлийн талаарх мэдээллийг үнэн зөв мэдээлэх;

3.1.5. биеийн халуунаа өдөрт 2-оос доошгүй удаа хэмжиж, өөрийн эрүүл мэндийн байдлыг хянах, коронавируст халдварн шинж тэмдэг илэрсэн даруйд харьяалах өрх, сум, тосгоны эмчид баталгааны хуудас дээрх утсаар мэдэгдэх;

3.1.6. ямар нэгэн зовиур илэрсэн, зөвлөгөө авах шаардлага гарсан, халуурах, хоолой хөндүүрлэх, хуурай ханиалгах, ядарч сульдах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтын эмч, 119, ХӨСҮТ-ийн 100 болон 80086829 дугаарын утсанд хандах;

3.1.7. томуу, томуу төст өвчний шинж тэмдгээс бусад төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтын эмч болон 119 дугаарын утсанд хандах;

3.1.8. гадаад улсын иргэн бол Интермед эмнэлгийн 80105577, SOS medical эмнэлгийн 91913122 утсанд хандаж, зөвлөгөө авах;

3.1.9. гэрийн ажиглалтад байх хугацаанд тусгаарлагдаж буй газрын байршлыг солих, тухайн газраас гарах, зочин урих, өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг эрсдэлд оруулах аливаа үйлдэл гаргахгүй байх;

3.1.10. бага насны хүүхэдтэй тусгаарлагдсан тохиолдолд түүний эрүүл, аюулгүй байдлыг нь хууль тогтоомжид заасны дагуу хариуцах;

3.1.11.гэртээ 2 цаг тутам агаар сэлгэлт хийж, гараа тогтмол угааж, хувийн ариун цэврийг сайтар сахих;

3.1.12.эмч, мэргэжилтэн болон бусад албаны хүнтэй харьцах үедээ амны хаалт хэрэглэж, хүн хоорондын зай барих;

3.1.13.гэрийн ажиглалтын хугацаанд гарсан ахуйн хог хаягдлыг уутанд хийж, амыг нь сайтар боож цуглуулан хогийн саванд хийх, хог хаягдал ил задгай хаяхгүй байх;

3.1.14.холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлагын талаар сануулсан баталгааны хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулан эрүүл мэндийн ажилтанд хүлээлгэн өгч, хууль тогтоомжийг зөрчихгүй байх.

3.2.Гэрийн ажиглалтад байгаа иргэн нь дүрэм, журам зөрчсөн тохиолдолд хөдөлгөөнийг хянах зорилгоор гэрийн хаалга, цонхонд хяналтын тусгай тэмдэглэгээ бүхий анхааруулах хуудас хэрэглэж болно.

3.3.Гэрийн ажиглалтад байгаа иргэн нь гэрээр тусгаарлахтай холбоотой дүрэм, журмыг удаа дараа зөрчсөн, гар утсаа унтраасан, байршлын талаарх мэдээллийг хяналт тавьж буй байгууллагад тухай бүр нь мэдээлээгүй, тусгаарлагдаж буй байршлаас хугацаа дуусаагүй байхад гарсан, ажиглалтад байгаа байрандаа бусдыг нэвтрүүлж, эрсдэлд оруулсан нөхцөлд түүнд хуулийн хариуцлага хүлээлгэж, гэрийн хаалганд лац тавих эсхүл ажиглах хугацааны үлдсэн хоногийн тоогоор тусгаарлах ажиглах байр руу шилжүүлж болно. Шилжүүлэхтэй холбоотой үүдэн гарах зардлыг тухайн этгээд өөрөө хариуцна.

Дөрөв. Байгууллага, албан тушаалтны авч хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1.Бүх шатны онцгой комиссын Шуурхай штаб:

4.1.1.УОКШШ нь гэрийн ажиглалтын үйл ажиллагаатай холбогдуулан бүх шатны шуурхай штабын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, шаардлагатай үүрэг чиглэл өгч биелэлтийг хангуулна.

4.1.2.сум, дүүргийн Онцгой комиссын Шуурхай штаб нь гэрийн ажиглалтад байгаа иргэний мэдээлэл, хаяг, утасны дугаарыг нягтлан шалгаж, баг, хорооны Засаг даргад хүргүүлэн дэг журмыг сахиулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хяналт тавина.

4.1.3.аймаг, нийслэлийн Шуурхай штаб нь сум, дүүргийн Шуурхай штаб, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, байнгын хяналт тавина.

4.1.4.батлагдсан тохиолдлыг эмнэлгийн болон түр тусгаарлах байранд тээвэрлэх, зохион байгуулалт хийх, удирдлага, зохицуулалтаар хангах ажлыг зохион байгуулна.

4.2. Баг, хорооны Засаг дарга:

4.2.1.харьяалах нутаг дэвсгэрт батлагдсан тохиолдол болон ойрын хавьтал бүртгэгдсэн үед ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрийн ажиглалтад байгаа иргэнийг хянах ажилтнуудын хуваарь, үүрэг, чиглэлийг урьдчилан гаргаж батална.

4.2.2.харьяалах нутаг дэвсгэрийн гэрийн ажиглалтын мэдээнд үндэслэн иргэнийг хянах ажилтан /цагдаа, улаан загалмай, баг, хорооны нийгмийн ажилтан гэх мэт/-ыг томилон, тусгаарлагдсан иргэн болон гэр бүлийн бусад гишүүдийг бүртгэж авна.

4.2.3.гэрийн ажиглалтад байгаа иргэнд хяналт тавих хяналтынжилтанг томилж ажиллуулах, хаана байгаа нь тодорхойгүй иргэнийг цагдаа, онцгой байдлын алба хаагчидтай хамтран эрэн хайх ажлыг зохион байгуулна.

4.2.3.гэрийн ажиглалтын байгаа иргэнд шаардлагатай ус, түлш, хүнс, эм гэх мэт нэн хэрэгцээт зүйлсээр хангах асуудлыг зохион байгуулна.

4.2.4.гэрийн ажиглалтад байгаа иргэдэд хэрэгцээт мэдээлэл бүхий зөвлөмжийг өгнө.

4.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар:

4.3.1.гэрийн ажиглалтад байгаа иргэнд эрүүл мэндийн хяналт хийх үйл ажиллагааг анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангана.

4.3.2.шаардлагатай тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гэрийн ажиглалтад байгаа иргэнд төрөлжсөн мэргэшлийн эмчийн тусламж үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө, мэдээллийг шуурхай авах үйл ажиллагааг зохицуулна.

4.3.3.гэрийн ажиглалтад байгаа иргэнд тавьж буй эрүүл мэндийн хяналт, үр дүнгийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ.

4.4. Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг:

4.4.1.аймаг, нийслэлд коронавируст халдварын батлагдсан тохиолдлыг эмнэлэг болон түр тусгаарлах байранд хэвтүүлэн хүчин төгөлдөр мөрдөж байгаа оношилгоо, эмчилгээний зааврын дагуу эмчилнэ.

4.4.2.эмнэл зүйн шинж тэмдэггүй болон хөнгөн хэлбэрийн батлагдсан тохиолдлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох тушаал, шийдвэрийн дагуу гэрт нь эсхүл энэхүү журмын 4.4.1-т заасан түр тусгаарлах байранд тусгаарлан эмчилнэ.

4.4.3.анхан шатны эрүүл мэндийн байгууллагын иргэдээс дуудлага хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн эмчтэй холбон иргэнд утсаар зөвлөгөө өгөх боломжоор хангана.

4.4.4.анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн дуудлагын дагуу аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн мэргэшлийн эмч ажиглалтад байгаа иргэнээс асуумж, биеийн байдлын талаарх мэдээлэл авч, утсаар зөвлөгөө мэдээллийг өгнө.

4.4.5.гэрийн ажиглалтад байгаа иргэнд тусламж, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай тохиолдолд орон нутагт Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын тусгаарлан ажиглах хэсэгт хэвтүүлэн эмчилгээнд хамруулна.

4.4.6.төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд улсын хэмжээнд лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагаас телемедицинээр зөвлөгөө авах, баг дуудах шаардлагатай тохиолдолд тусгаарлан ажиглах хэсэгт хэвтүүлэн эмчлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

4.4.7.эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ эрхэлсэн дарга нар хамтран шийднэ.

4.4.8.голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг нийслэлд Зоонозын өвчин судлалын үндэсний төв, холбогдох мэргэжлийн байгууллага, аймагт ЗӨСТ, ЗӨСТ-гүй аймагт Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум, тосгонд эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг гүйцэтгэж, зөвлөмжийг тухайн батлагдсан тохиолдлын гэр бүлд өгнө.

4.4.9.батлагдсан тохиолдлыг нийслэлд дүүргийн хариу арга хэмжээний баг, орон нутагт шуурхай хариу арга хэмжээний баг эмнэлэг, түр тусгаарлах байранд хүргэж, зохих арга хэмжээг авна.

4.4.10.орон нутагт бүртгэгдсэн сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтлын шинжилгээг тухайн орон нутгийн шуурхай хариу арга хэмжээний баг авч, сорьцыг шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэн, хамгийн ойрын Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн вирус судлалын лабораторид хүргэж шинжлүүлнэ.

4.4.11.сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгтэй, сэжиг бүхий, тулгамдсан асуудалтай батлагдсан тохиолдол болон ойрын хавьтлыг Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төв тээвэрлэж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

4.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв:

4.5.1. харьяалах нутаг дэвсгэрийн гэрийн ажиглалтын мэдээнд үндэслэн иргэнийг хянах эмнэлгийн мэргэжилтнийг томилон, тусгаарлагдсан иргэн болон гэр бүлийн бусад гишүүдийг бүртгэж авна.

4.5.2. тусгаарлагдсан ажиглалтад байгаа иргэнд биеийн байдал, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгийн талаар мэдээлэх, зөвлөгөө авах, нээлттэй утасны дугаарыг тэмдэглүүлж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан “Батлагдсан тохиолдлын хавьтлын ажиглалтын хуудас”, бөглөх зааврыг танилцуулна.

4.5.3. эрүүл мэндийн талаар мэдээлэх хугацаа, халдвар хамгааллын дэглэм, ажиглалтад байх иргэн болон түүний гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг сануулан, утсаа байнга нээлттэй байлгаж, ажиглалтад буй газраас гарч болохгүй талаар байнга анхааруулна.

4.5.4. гэрийн ажиглалтад байгаа ойрын хавьтал болсон иргэнтэй өдөрт 2 удаа утсаар холбогдож, шинж тэмдэгийн тандалт хийж, тэмдэглэл хөтөлнө.

4.5.5. эрүүл мэндийн талаарх мэдээллээ өгөхгүй байгаа иргэнийг утсаар тодруулж, утас нь холбогдох эсэхээс үл хамаарч нөхцөл байдлын мэдээг сум, хорооны цагдаагийн хэсэгт мэдэгдэнэ.

4.5.6. иргэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл, шинж тэмдгийн эмчилгээ, анхаарах асуудлын талаар хариу өгнө.

4.5.7. төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг шаардлагатай тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, харьяа аймаг, дүүргийн эмнэлгийн холбогдох мэргэшлийн эмчийг иргэнтэй холбон зөвлөгөө, мэдээлэл өгүүлнэ.

4.5.8. нэн шаардлагатай тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн гэрээр үзлэг хийж, шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.5.9. гэрээр тусгаарлагдсан иргэн дэглэм, журам зөрчсөн, эрүүл мэндэд хяналт тавих үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулсан тохиолдолд энэ талаар цагдаа, онцгой байдлын ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.

4.5.10. сум, дүүрэг, өрх, тосгоны Эрүүл мэндийн төвийн Шуурхай хариу арга хэмжээний баг нь “Гэрийн ажиглалтын баталгааны хуудас”-ыг бөглүүлж, 1 хувийг сум, дүүргийн Шуурхай штабын цагдаагийн албан хаагчид цахимаар хүргүүлнэ.

4.6. Коронавируст халдварын хавьтлын тандалт судалгаа, мэдээллийн урсгал:

4.6.1. Нийслэлд ХӨСҮТ, орон нутагт аймгийн Эрүүл мэндийн газар батлагдсан тохиолдлын талаархи мэдээллийг тухайн шатны шуурхай хариу арга хэмжээний багт өгнө.

4.6.2. батлагдсан тохиолдлын гэр бүлийн ойрын хавьтлыг тухайн шатны Эрүүл мэндийн байгууллага, бусад ойрын хавьтлыг ХӨСҮТ-ийн шуурхай хариу арга хэмжээний баг тогтооно.

4.6.3. аймаг, нийслэлийн шуурхай хариу арга хэмжээний баг батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын эрүүл мэндийн эрсдэл /жирэмсэн, архаг суурь өвчтэй, сэтгэцийн эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн, гемодиализ, хавдрын хими, туяа гэх мэт өдөр тутмын эмчилгээ асаргаа шаардлагатай/-тэй эсэхийг нарийвчлан судалгааг хийж, тухайн шатны хариу арга хэмжээний багт хүргүүлнэ.

4.6.4. гэрийн ажиглалтад байгаа иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийг тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллага цахим системд бүртгэж оруулна.

4.7. Тагнуул, цагдаа, онцгой байдлын байгууллага:

4.7.1. гэрийн ажиглалтад байгаа иргэнд хяналт тавих, хаана байгаа нь тодорхойгүй иргэнийг баг, хорооны Засаг даргатай хамтран эрэн хайх ажлыг зохион байгуулна.

4.7.2.НЭМГ, орон нутагт аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг, БОЭТ, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн шуурхай хариу арга хэмжээний багаас “Гэрийн ажиглалтын баталгааны хуудас”-ны зургийг цахимаар авч мэдээллийн сан үүсгэнэ.

4.7.3.хамгаалалтын бүсэд үүрэг гүйцэтгэх хугацаанд өдөр бүр Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай штабт 10:00 цаг, 18:00 цаг, 24:00 цагт мэдээ өгч, тэмдэглэл хөтөлнө.

4.7.4.гэрийн ажиглалтын болон гэрээр эмчлэгдэн хяналтад байх хугацаанд гэр бүлийн хүчирхийлэл гаргасан батлагдсан тохиолдлыг эмнэлэгт, ойрын хавьтлыг тусгаарлах байранд шилжүүлж тусгаарлалтын хугацаа дууссаны дараа холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах бөгөөд хувийн хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмссөн байна.

4.8. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар:

4.8.1.ажиглалтад байгаа асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй 0-18 насны эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гишүүдэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай тохиолдолд түр хамгаалах байранд мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хариу үйлчилгээг 24 цагаар үзүүлнэ.

4.9. Хүмүүнлэгийн байгууллага:

4.9.1.гэрийн ажиглалтад байгаа тусламж үйлчилгээ шаардлагатай эмзэг бүлгийн өрхөд хоол хүнс бусад бараа материалын хангалт хийх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

4.10. Сууц өмчлөгчдийн холбоо:

4.10.1.байр орон сууцны цэвэрлэгээ, үйлчилгээнд хэрэглэгдэх угаалга, цэвэрлэгээ, халдваргүйжилтийн бодис, ажилтанд зориулан хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийг бүрдүүлнэ.

4.10.2.орон сууцны нийтийн эзэмшлийн зай талбайд чийгтэй цэвэрлэгээг өдөрт 2 удаа хийж, халдваргүйжүүлнэ.

4.10.3.оршин суугчдыг гар халдваргүйтгэх нөхцөлөөр хангаж, лифт давхруудад гар халдваргүйжүүлэгч суурилуулна.

4.10.4.иргэдийг халдвараас сэргийлэх мэдээ, мэдээллээр хангах ажлыг дүүрэг, хороотой хамтран зохион байгуулна.


4.10.5.ойрын хавьтал болон гэрээр тусгаарлагдан эмчлэгдэж байгаа иргэнийг дүүрэг, хороотой хамтран хяналт тавина.

Тав. Бусад

5.1.Ажил үүргийн хувьд олж мэдсэн хувь хүний нууцыг албан тушаалтан задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

5.2.Энэхүү түр журмыг зөрчсөн албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд Гамшгаас хамгаалах тухай хууль, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг үндэслэн Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэний тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг
зохицуулах түр журмын хавсралт



ГЭРИЙН АЖИГЛАЛТЫН БАТАЛГААНЫ ХУУДАС

Овог, нэр
Регистрийн дугаар.....
Утасны дугаар.....
Гэр (оршин суугаа)-ийн хаяг.....
Ажиглалтад байх хугацаа

Миний бие Улсын Онцгой комиссын даргын дугаар тушаалаар батлагдсан “Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 3 дахь хэсэгт заасны дагуу гэрийн ажиглалтад байхдаа дараах үүргийг дагаж мөрдөнө:

1. Хавьтлаар тооцогдож гэрийн ажиглалтад байх үед харьяалах эрүүл мэндийн байгууллага (өрх, сум, тосгон)-д мэдэгдэнэ.

2. Гэрээр тусгаарлагдаж буй хаяг, байршлаасаа гарахгүй, өөрчлөхгүй байхаа баталж байна.

3. Биеийн халуунаа өдөрт 2-оос доошгүй удаа хэмжиж, өөрийн эрүүл мэндийн байдлыг хянаж, коронавируст халдвар-ын шинж тэмдэг илэрсэн даруйд харьяалах өрх, сум, тосгоны эмчид утсаар мэдэгдэнэ.

4. Гэртээ агаар сэлгэлтийг 2 цаг тутамд, чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийнэ.

5. Гэрийн ажиглалтад байх хугацаанд гэрээс гарахгүй, зочин урихгүй, өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг эрсдэлд оруулахгүй байна.

6. Гэрээр ажиглалтад хяналт тавьж буй албан хаагчдын үйл ажиллагаанд саад учруулахгүй, гэрээр тусгаарлах дэглэм, журмыг зөрчихгүй байх үүрэг хүлээнэ.

7. Дүрэм, журам зөрчсөн нөхцөлд гэрийн хаалгаа лацдуулах эсхүл тусгаарлан ажиглах байр руу шилжиж, түүнтэй холбогдон гарах зардлыг нөхөн төлнө.

Дээрх үүргийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан дараах хариуцлага хүлээхийг ойлгож байна.

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4. Иргэн халдварт өвчнийг бусдад зориуд халдаасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийг зөрчвөл хүнийг таван зуун нэгжтэй /1 нэгж 1000 төгрөг/ тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Эрүүгийн хуулийн 15.6 дугаар зүйл. 5.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин халдаах нөхцөлийг зориуд санаатайгаар зөрчиж, халдварт өвчин тархах нөхцөл бүрдүүлсэн, эсхүл бусдад халдаасан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял эдлүүлнэ.

БАТАЛГАА ГАРГАСАН ИРГЭНИЙ НЭР, ГАРЫН ҮСЭГ..... /...../
БАТЛАН ДААСАН ИРГЭНИЙ НЭР, ГАРЫН ҮСЭГ /...../
РЕГИСТРИЙН ДУГААР:.....

МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨГӨӨ АВАХ 24 ЦАГИЙН АЖИЛЛАГААТАЙ УТАСНЫ ДУГААР:
.....

БАТАЛГАА АВСАН АЛБА ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛ,
НЭР, ГАРЫН ҮСЭГ..... /...../

Улсын онцгой комиссын даргын 2021 оны
43 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**ТУСГААРЛАН ЭМЧЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ**

УХАУ164

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү түр журмаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэггүй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн, гэрээр тусгаарлан хянахад эрсдэлтэй батлагдсан тохиолдлыг эмнэлгийн бус байранд /Цаашид "түр тусгаарлах байр" гэх/-д тусгаарлан хянах, эмчлэх үйл ажиллагааг зохицуулах, оролцогч талуудын үүрэг хариуцлага, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

1.1. Түр тусгаарлах байранд эмчлэх үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын баталсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн батлагдсан тохиолдлыг гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах түр зааврыг мөрдлөг болгоно.

1.2. Түр тусгаарлах байрны үйл ажиллагаанд шаардагдах холбогдох зардлыг санхүүжүүлэх журмыг Эрүүл мэнд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батална.

Хоёр. Түр тусгаарлах байрны зохион байгуулалт

2.1. Түр тусгаарлах байрыг сонгох, бэлэн байдлыг хангуулахыг аймаг, дүүргийн онцгой комисс хариуцна. Дараахь объектыг түр тусгаарлах байраар сонгоно. Үүнд:

- 2.1.1. зочид буудал
- 2.1.2. амралтын газар, сувилал
- 2.1.3. оюутан, сурагчдын дотуур байр
- 2.1.4. бусад

2.2. Аймаг, сум, дүүргийн онцгой комиссоос ажлын хэсэг (эрүүл мэнд, мэргэжлийн хяналт, цагдаа, онцгой гэх мэт) тусгайлан томилон түр тусгаарлах байрыг сонгож дүгнэлт гаргана.

2.3. Түр тусгаарлах байрыг орон нутагт аймгийн нэгдсэн эмнэлэг, нийслэлд дүүргийн Эрүүл мэндийн төв нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана.

2.4. Батлагдсан тохиолдлыг гэрээс нь түр тусгаарлах байранд тухайн сум, дүүргийн хариу арга хэмжээний баг тээвэрлэнэ.

2.5. Түр тусгаарлах байрыг ногоон, шар, улаан бүсэд хуваан урсгал зохицуулалтыг тухайн сум, дүүргийн Эрүүл мэндийн байгууллага хийнэ.

2.6. Эмч мэргэжилтэн, бусад алба хаагчийн байрлах өрөө, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг тайлах хэсэг, гал тогооноос тусгаарлан ажиглах өрөөнд хоол зөөвөрлөх, хоолны хэрэгслийг гал тогоонд хүргэх болон хог хаягдлыг зөөвөрлөх чиглэл зэрэг орох, гарахыг хориглосон хэсэгт нэг чигийн урсгалаар хөдөлгөөнийг давхцуулахгүй байхаар анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна.

2.7. Өрөө тус бүрт эмчтэй холбоо барих утасны жагсаалт, хяналтын үед мөрдөх санамж байрлуулна.

2.8. Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллана. Өвчтөний биеийн байдал хүндэрсэн тохиолдолд нийслэлд харъяа дүүргийн хариу арга хэмжээний баг, орон нутагт аймгийн ЭМГ-ын эмнэлзүйн болон шуурхай ажиллагааны багт яаралтай мэдэгдэж холбогдох арга хэмжээг авч тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Гурав. Аймаг, дүүргийн онцгой комиссын шуурхай штабын эрх, үүрэг

- 3.1. Түр тусгаарлах байрны өмчлөгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулна.
- 3.2. Түр тусгаарлах байрны өрөө, тасалгаа тус бүрийн орны тоо, байршлыг нарийвчлан судалж, иргэдийг байршуулах хуваарийг урьдчилан төлөвлөнө.
- 3.3. Түр тусгаарлах байрны нөхцөл, дэг журам, хоол хүнсний асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэнэ.
- 3.4. Иргэдийн хэрэглэсэн гудас, зөөлөн эдлэлд халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Иргэний эрх, үүрэг

- 4.1. Түр тусгаарлах байранд үүрэг гүйцэтгэж буй эмчийн хуваарилсан өрөөнд тусгаарлагдаж, тогтоосон хугацаанд тусгаарлалтын дүрэм, журмыг мөрдөнө.
- 4.2. Түр тусгаарлах байранд ажиллаж буй албан хаагчдын хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.
- 4.3. Иргэн эрүүл мэндийн байдлаа утсанд нь ирсэн тандалтын системийн цахим асуумжийг бөглөж эрүүл мэндийн ажилтанд үнэн зөв мэдээлэл өгнө.
- 4.4. Түр тусгаарлах байранд орохоос өмнө өөрийн эрүүл мэндийн байдал, шашны зан үйлээр хориглосон болон харшлах, эм, хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээллийг урьдчилан мэдэгдэнэ.
- 4.5. Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байж, эмч мэргэжилтэн болон бусад хүнтэй харьцах үедээ амны хаалт хэрэглэнэ.
- 4.6. Өрөөний цонхны салхивчийг 2 цаг тутамд 15 минут нээж, агааржуулалт хийж, зааврын дагуу гараа тогтмол угааж, хувийн ариун цэврийг сахина.
- 4.7. Байрны эд хогшлыг зориулалтын дагуу, ариг гамтай ашиглана
- 4.8. Бага насны хүүхэдтэй тусгаарлагдсан тохиолдолд түүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг нь хариуцна.
- 4.9. Тусгаарлагдсан иргэний зовиур нэмэгдэх /ханилга нэмэгдэх, амьсгаадах, тогтмол халуурах, цээжээр өвдөх, бөөлжих, суулгах гэх мэт/ үед хяналтын эмчид утсаар хандана.
- 4.10. Тусгаарлагдаж байгаа иргэнд дараах үйлдлийг хориглоно.
 - 4.10.1. Ажилтан, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, доромжлох, заналхийлэх, биед нь халдах, аливаа зүй бус үйлдэл гаргах.
 - 4.10.2. Түр тусгаарлах байранд бусдын эрүүл мэндэд хохирол учруулахуйц хурц үзүүртэй эд зүйл, архи, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, түргэн гэмтэж, муудах хүнсний бүтээгдэхүүн авч орох, хэрэглэх, эргэлтээр авах.
 - 4.10.3. Өрөөнөөс гарах, өрөөний цонхоор хог, тамхины иш, нус, цэр, шүлсээ хаях болон эд зүйл дамжуулах, бусадтай харилцах.
 - 4.10.4. Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, өдөөн турхирах, буруу ташаа мэдээлэл тараах болон түгээх.
- 4.11. Түр тусгаарлах байрнаас гарах үед иргэн өөрийн ачаа тээшийн гадаргууг халдваргүйжүүлэх бодис бүхий уусмалаар арчиж халдваргүйжүүлнэ.
- 4.12. Гэрээсээ хөнжил, цагаан хэрэгсэл авч ирсэн тохиолдолд гэртээ харьсан даруйд угааж, халдваргүйжүүлэх.